

ХУРАЛДААНЫ ТОЙМ

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН 2014 ОНЫ 8 ДУГААР ХУРАЛДААН

Хуралдаан 2014 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн 10 цаг 13 минутад эхэлж, 11 цаг 47 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж, нийт 1 цаг 34 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	Засгийн газрын тохируулагч агентлаг Цөмийн энергийн газрын Цөмийн хяналтын хэлтсийн даргын албан тушаалд томилуулахаар санал болгосон албан тушаалтанд Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>Засгийн газрын тохируулагч агентлаг Цөмийн энергийн газрын Цөмийн хяналтын хэлтсийн даргын албан тушаалд Баатарын Батгэрэлд дүгнэлт гарган нэр дэвшүүлж, томилуулахаар тус агентлагийн дарга Н.Тэгшбаярт санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
2	Төрийн албаны зөвлөлийн Шүүхийн ерөнхий зөвлөлийн дэргэдэх Салбар зөвлөлийн даргыг томилох тухай	<p>Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн "Гурав"-ын 3.3, Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. Төрийн албаны зөвлөлийн Шүүхийн ерөнхий зөвлөлийн дэргэдэх Салбар зөвлөлийн даргаар Шүүхийн хүний нөөцийн газрын дарга</p>

		<p>Лувсандоржийн Өлзийсайханыг томилох.</p> <p>2. Салбар зөвлөлийн ажлыг хууль, тогтоомж, холбогдох дүрэм, журамд нийцүүлэн гүйцэтгэхийг Салбар зөвлөлийн дарга Л.Өлзийсайханд даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
3	Зарим албан хаагчдад төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв олгуулах тухай	<p>Төрийн албаны тухай хуулийн 20 дугаар зүйл, “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журмыг батлах тухай” Улсын Их Хурлын 1995 оны 73 дугаар тогтоолоор баталсан журмын 2, 6 дахь заалт “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журамд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын 2000 оны 20 дугаар тогтоолын 1-д заасны дагуу төрийн захиргааны тэргүүн болон эрхэлсэн түшмэлийн албан тушаалын зэрэг дэв олгуулахаар ирүүлсэн саналыг хэлэлцээд ,8 албан хаагчид тэргүүн түшмэлийн, 23 албан хаагчид эрхэлсэн түшмэлийн зэрэг дэв олгуулах саналыг Засгийн газарт уламжлахаар шийдвэрлэв.</p>
4	Булган, Дархан-Уул, Орхон аймагт ажилласан Ажлын хэсгийн тайлан	<p>Орхон, Архангай, Дархан-Уул аймагт ажилласан Ажлын хэсгийн тайланг сонсож хэлэлцээд, Орхон, Архангай, Дархан-Уул аймаг дахь Салбар зөвлөлүүдэд, Аймаг, нийслэл дэх Салбар зөвлөлүүдэд тус тус зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэлээ.</p>
5	Бусад асуудал	

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

